



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2010 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 309

Улаанбаатар хот

Г Тогтоолд өөрчлөлт оруулах тухай ᠓

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.1, “Худалдаа хөгжлийн банк” ХХК-ны 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 4/3785 тоот албан бичиг, Монголбанкны 2010 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 3/3463 болон 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 1а/1783 тоот албан бичгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 135 тоот тогтоолын 1 дэх заалтын “25 000 000 хүртэлх америк долларын хоёрдогч өглөгийг” гэснийг хүчингүй болгосугай.

2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 7.1-д үнэт цаасыг хаалттай худалдахаар гаргахад Хороонд бүртгүүлэх журам хамаарахгүй байхаар заасныг үндэслэн “Худалдаа хөгжлийн банк” ХХК-иас олон улсын үнэт цаасны зах зээлд хаалттай хэлбэрээр худалдах 30 000 000 хүртэлх америк долларын хоёрдогч өглөгийг үнэт цаасны бүртгэлд бүртгэх шаардлагагүй гэж үзсүгэй.

3. Энэ тогтоолын 2-т заасан хоёрдогч өглөгийг зохих журмын дагуу Монголбанкны хяналт, зөвшөөрлийн дагуу гаргахыг “Худалдаа хөгжлийн банк” ХХК /Гүйцэтгэх захирал Б.Мэдрээ/-д зөвлөсүгэй.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-т даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН